МОНГОЛ УЛС
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2018 оны 06 сарын 21 өдөр | Дугаар А/287 | Мандалговь

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 5.1.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. ITRF-97 солбицолын тогтолцоонд хийгдсэн кадастрын зургийг UTM тусгагт хөрвүүлэхэд систем хоорондын зөрүүнээс үүдэж эдлэн газрын кадастрын зургийн талбайн хэмжээ зөрүүтэй гарч байгаа 5 нэгж талбарын жагсаалтыг хавсралтаар батлсугай.

Хоёр. Кадастрын зургийн талбайн хэмжээ, хаягийн өөрчлөлтийг аливаа шилжилт хөдөлгөөн хийлгэхээр газар өмчлөгч хүсэлт гаргасан тухай бүр шийдвэрлүүлж газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах иргэд олон нийтэд мэдээлэл өгч ажиллахыг Сайнцагаан сумын засаг дарга (Р.Мөнхтогтох), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2008 оны 150 дугаар захирамжийн хавсралтын 72, 2005 оны 319 дугаар захирамжийн хавсралтын 105, 2015 оны А/278 дугаар захирамжийн хавсралтын 247, 248, 249 дэх заалтуудыг хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөв. Газрын талбайн хэмжээний өөрчлөлтийг тухай бүр гарсан шийдвэрийг үндэслэн газар өмчлөгч иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй, хууль тогтоомжид заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Улсын бүртгэл хэлтэс (Ж.Өлзийжаргал)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

*Дундговь аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн А/287 дугаар захирамжийн хавсралт*

| № | Өмчлөгчийн | | | Өмнөх захирамжийн | | Өмнөх газрын | | Газрын | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Овог | Нэр | Регистрийн дугаар | Огноо дугаар | Холбогдох хэсгийн дугаар | Нэгж талбарын дугаар | Хэмжээ /м2/ | Хэмжээ /м2/ | Байршил | Үнэ /төгрөг/ |
| 1 | Сугир | Давааням | ЗЮ58122201 | 2008 №150 | 38 | 111101391 | 1184 | 1108 | Мандал 2-246 | 3545600 |
| 2 | Цэвээн | Овлог | ЗГ38071111 | 2005 №319 | 105 | | 900 | 900 | Боржигон 18-29 | 2160000 |
| 3 | Ганбат | Мөнх-Оргил | ЗФ90020611 | 2015 А/278 | 249 | | 900 | 700 | Шарангад 5-133 | 1680000 |
| 4 | Ганбат | Мөнхбат | ЗЮ94072613 | 2015 А/278 | 247 | | 900 | 700 | Шарангад 5-134 | 1680000 |
| 5 | Хүрэлчөдөр | Жаргал | ЗЮ70030600 | 2015 А/278 | 249 | | 900 | 700 | Шарангад 5-132 | 1680000 |